

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Нэг: Зохион байгуулалтын талаар :

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Үнэлгээний баг байгуулах тухай” Б/78 дугаар тушаалаар байгуулагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Зам, тээврийн яамны 8 газрын нийт 112 албан хаагчийг /тус жагсаалтад газар, хэлтсийн дарга нар багтсан/ үнэлгээг ихээс бага руу эрэмбэлэн үнэлгээний ангилалд хамруулан үнэллээ.

“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 7.2 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний багийн гишүүд нууцын баталгаа гаргаж ажиллав. Мөн тус журмын 6.2, 6.5 дахь заалтуудад заасны дагуу гүйцэтгэлийн үнэлгээг нэгжийн даргын үнэлсэн үнэлгээний оноогоор эрэмбэлж, “Маш сайн”, “Хэвийн”, “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамаарах албан хаагч нэг бүрийн тайлан, үнэлгээний хуудсыг нягтлах замаар үнэлгээ өгч ажилласан. Үүнээс:

1. Маш сайн ангилалд- 98
2. Хэвийн ангилалд-14
3. Шинээр томилогдсон, хугацаа болоогүй-4

Хоёр: Нэгжийн даргын үнэлгээтэй холбоотой гомдлын талаар:

Албан хаагчдаас шууд харьяалах нэгжийн даргын үнэлсэн үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй тухай гомдол, санал гараагүй байна.

“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу шинээр томилогдсон болон урт хугацааны чөлөөтэй шалтгаанаар үнэлгээнд хамрагдахгүй төрийн захиргааны 4, төрийн үйлчилгээний 1 (жолооч орон тооны бус) сайдын ажлын албаны 1 албан хаагч байна.

Гурав: Үнэлгээнд баримталсан зарчим, эрх зүйн зохицуулалтын талаар:

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ажлын хэсгийн хурлаар үнэлгээнд баримтлах зарчим хэлэлцэн тохирсон.

Үүнд: Нэгжийн удирдлагын үнэлсэн “Хэвийн” ангилалд хамаарах албан хаагчийн үнэлгээ хэвээр үлдээж, “Маш сайн” ангилалд хамаарч байгаа алба хаагчдыг журмын дагуу үнэлсэн.

Төрийн үйлчилгээний 9 албан хаагчийн эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг шууд харьяалах нэгжийн дарга үнэлэх талаар ажлын хэсэг шийдвэрлэсэн тул

ТЗУГ-ын дарга төрийн үйлчилгээний алба хаагчдыг үнэлсэн байна. Журмын дагуу сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчийг үнэлгээний жагсаалтад оруулсан ч урамшуулалд хамрагдахгүй болно.

Дөрөв: Үнэлгээний явцын зөрчил, дутагдлын талаар:

4.1. Үнэлгээний багаас үнэлгээ баталгаажуулах явцад гарсан нийтлэг зөрчилд албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг журамд заасны дагуу төлөвлөөгүй, нэг ажлыг хэд хэдэн албан хаагч ажлын тайланд тайлагнасан, нэг ажлыг хэд хэд салган биелэлтийг 100 хувиар үнэлсэн, хүрсэн үр дүнгийн талаар тоо баримт дурдаагүй, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний биелэлт хангалтгүй зэрэг нийтлэг дутагдалтайн улмаас үр дүнг үнэлэх асуудалд хүндрэл үүссэн хэдий ч Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 442 дугаар тогтоолын тайлбар хэсгийн Төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу төлөвлөсөн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг харгалзан, төрийн жинхэнэ албан хаагчийн эрхзүйн байдлыг дордуулахгүй байх зарчмыг баримтлан энэ журмын дагуу үнэлнэ" гэж заасныг баримтлан ажилласан.

4.2. Албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод заасан нэг арга хэмжээг олон дэд хэсэгт хуваан төлөвлөсөн, төрийн жинхэнэ албан хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг үүргийг олон арга хэмжээ болгон төлөвлөсөн алдаа гарсан байна. Мөн энэ оны эхний хагас жилийн байдлаар нэгжийн удирдлага 3 удаа солигдсон тул албан хаагчид төлөвлөгөөгөө 6 сард батлуулсан байна.

4.3. Авто зам, автотээвэр, төмөр замын хяналтын улсын байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан адилхан, давхцалтай, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ажлын байрны тодорхойлолт, хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд зааг ялгааг гаргаж төлөвлөх, газар хэлтсийн дарга нар батлахдаа сайтар нягтлах шаардлагатай байна.

4.4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "тушаал шийдвэр, цаг үеийн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг тайлагнах, архивын нэгжид баримт бичиг бүрдүүлж өгөх, албан байгууллага, иргэдээс ирсэн өргөдөл гомдолд хариу өгөх, хийсэн ажлаа олон нийтэд сурталчлах, ажлын цаг баримтлан ажиллах, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох, төрийн албаны тухай болон хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах" гэх мэтчилэн ажлуудыг төлөвлөж, тухай бүр биелүүлсэн тул 100 оноо үнэлж байгаа нь үндсэн хэрэгжүүлэх ажлын биелэлт, үнэлгээний дундаж оноо өндөр гаргахад нөлөөлж байна.

4.5. Төрийн үйлчилгээний албан хаагчид ижил төстэй төлөвлөгөө батлуулсан, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлаа тодорхой тайлагнаагүй, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг уялдуулж төлөвлөөгүй зэрэг нийтлэг алдаа гарсан байна.

Тав: Үнэлгээний дүнг үндэслэн урамшуулал олгох талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь

заалтад орсон өөрчлөлтийн дагуу 85-100 үнэлгээтэй албан хаагчдад үндсэн цалинг 100 хувиар, 70-84 хувийн үнэлгээтэй албан хаагчдад үндсэн цалинг 50 хувиар тус тус тооцож, урамшуулал олгохоор үнэлгээний баг шийдвэрлэж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар яамны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, үнэлгээг дахин эрэмбэлж ажиллав.

Зургаа: Санал, дүгнэлт:

“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.16-д заасны дагуу үнэлгээний багаас дараах санал, дүгнэлтийг хүргүүлж байна. Үүнд:

6.1. Дараах зүйлсийг газар хэлтсийн дарга нар анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- ✓ Нэгжийн дарга нар албан хаагчийн төлөвлөгөөг батлахдаа “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 2.4-т “Нэгжийн дарга нь албан хаагчийн төлөвлөгөөнд албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүрэг, байгууллага болон нэгжийн төлөвлөгөө дэх зорилт, арга хэмжээ тусгагдсан эсэхийг хянан, тухайн жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системд баталгаажуулна” гэж заасан хугацаанд албан хаагчдын төлөвлөгөөг батлуулж хэвших;
- ✓ Албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүрэг болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд бүрэн тусгуулах, хяналт тавьж төлөвлөгөөг батлах,
- ✓ Арга хэмжээ тус бүрийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж боловсруулсан эсэх, арга хэмжээний зорилтот түвшинг улирал бүр хэрэгжүүлэхээр томъёолж, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөсөн эсэхийг хянах;
- ✓ Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, төлөвлөсөн арга хэмжээний тоо харилцан адилгүй байгаагаас хамааран ажлын ачаалалтай уялдуулах талаар дотоод зохион байгуулалтыг хийх;
- ✓ Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэхэд төлөвлөсөн хугацаанд бүрэн биелүүлсэн эсэхийг харгалзах, үнэн бодитоор журамд заасны дагуу үнэлдэг байх;
- ✓ Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”-ын 2.3.2-т заасны дагуу үнэлэх;

6.2. Албан хаагчид дараах зүйлсийг нар анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- ✓ Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлаа товч бөгөөд тоо баримттай, тодорхой, үг үсэг, утга найруулгын алдаагүй тайлагнах, тайлангийн чанарт анхаарах,
- ✓ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу төлөвлөгөөг төлөвлөдөг байх;

- ✓ "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу төлөвлөгөөг заасан хугацаанд батлуулах, тайлагнах;
- ✓ Албан хаагчид мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө дээрх аргачлалын 2.6-д заасны дагуу төлөвлөх
- ✓ Албан хаагч өөрийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай сургалтад хамрагдах талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, нэгжийн дарга болон сургалт хариуцсан албан хаагчид мэдээлэх,
- ✓ Албан хаагчид хуулиар хүлээсэн үүргийн дагуу байнга, тогтмол хийгддэг арга хэмжээг төлөвлөхгүй байх. Тухайлбал: ХАСХОМ гаргаж өгөх, удирдлагыг мэдээллээр хангах, албан бичиг боловсруулах гэх мэт.
- ✓ Албан хаагчид төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа товч бөгөөд тодорхой тоо баримттай, утга найруулга, үг үсгийн алдаагүй, төлөвлөсөн хугацаанд бүрэн тайлагнаж хэвших

6.3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны "Аргачлал, загвар батлах тухай" 98 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх асуудлаар яамны нэгж, хэлтсийн дарга нар болон нийт албан хаагчдад сургалт зохион байгуулж ажиллах зайлшгүй шаардлага үүссэн тул Төрийн захиргааны удирдлагын газар 2025 оны III улиралд сургалтыг зохион байгуулж ажиллахыг үнэлгээний багаас зөвлөмж байна.

Танилцсан:


Төрийн нарийн бичгийн дарга



С.Батболд

Үнэлгээний багийн дарга:


Бодлого, төлөвлөлтийн газрын дарга



Г.Батбаяр

Гишүүд:

Салбарын хяналтын газрын шинжээч



П.Мөнхбат

Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын шинжээч



Д.Бямбасүрэн

Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн




Ц.Нэмэхжаргал

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн



Б.Байгалмаа

Автотээврийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн



Ц.Санчирдорж

Авто замын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн



Ж.Оюунжаргал

Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын
газрын мэргэжилтэн



Э.Солонго

Төмөр зам, далайн тээврийн бодлого
зохицуулалтын газрын
мэргэжилтэн



Б.Идэр

Нарийн бичгийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын
ахлах шинжээч



Орхонтамир

--oOo--